



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 03 өдөр

Дугаар A/17

Улаанбаатар хот

Бүртгэлийн маягт батлах тухай

Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3 дахь хэсэг, Эм, эмнэлгийн хэрэгсэл, хяналт зохицуулалтын газрын даргын “Чанарын гарын авлага, менежментийн тогтолцооны журам батлах тухай” 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/14 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын Эм шинжлэх лабораторид ашиглах анхан шатны бүртгэлийн маягтыг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. Анхан шатны бүртгэлийн маягтыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Эм шинжлэх лаборатори (Ш.Сонинхүү)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Л.Батзориг)-т тус тус даалгасугай.

3.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан “Бүртгэлийн маягт батлах тухай” 2022 оны 02 сарын 21-ний өдрийн А/28 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ЗЭНДМАА